

“ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2-р сарын 26-ны өдөр

№ 23/01

Булган хот

ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 61.1.9 болон 63.5 дахь заалт, Тооллогын комиссын 1, 2, 3, 4 дүгээр саналын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компани нь 2022 онд ноогдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТУЯА

ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2-р сарын 26-ны өдөр

№ 23/02

Булган хот

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, урамшууллын дүнг батлах тухай.

Компанийн хуулийн 62.1.7 дах заалт болон Тооллогын комиссын 5, 6, 8, 9 дүгээр саналын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн ТУЗ болон хараат бус гишүүдийн дараах бүрэлдхүүнтэйгээр сонгосугай:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд:

1. Н. Одонбилэг ✓
2. О. Маралмаа ✓
3. Ж.Жадамба ✓
4. Б.Батчимэг ✓
5. Х.Гончигсүрэн ✓
6. Л.Цангилагбар ✓

ТУЗ-ын хараат бус гишүүдэд:

1. Л.Гантуяа ✓
2. З.Дэлгэрмаа ✓
3. Ц.Сайнжаргал ✓

2. ТУЗ-ын болон Хараат бус гишүүдийн 2023 оны урамшууллын дүнг нэг гишүүний 300 000 /гурван зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТУЯА

“ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2-р сарын 26-ны өдөр

№ 23/03

Булган хот

Компанийн хувьцааг хуваах, дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулахыг батлах тухай.

Компанийн хуулийн 51, 62 дугаар зүйл болон Тооллогын комиссын 7 дугаар саналын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

9. “Эрдэнэт суварга” ХК-ийн нийт гаргасан 156054 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийн 214 хувааж, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 33 395 556 ширхэг энгийн хувьцаа болгон хуваасугай.
10. “Эрдэнэт суварга” ХК-ийн хувьцаа хуваах төслийг энэ тогтоолын 1-р хавсралтаар баталсугай.
11. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн нэрлэсэн үнэ, тоо өөрчлөгдөх тул компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлтийг оруулж, оруулсан өөрчлөлтийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Н.Одонбилэг/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТУЯА